



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

"Орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн" нийцлийн аудит  
ҮАГ-НАГ/2018/02-НА-ХөТАГ

УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2017 оны 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэсэн нийцлийн аудитын тайлан:

**Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулагдсан эсэхэд хяналт тавьдаггүй зөрчил байсаар байна.**

**Хөвсгөл аймаг  
2018 оны 11 дүгээр сар**



"Хөгийн сав" арга хангаа-Мөрөн сум



ОНХС-ийн хөрөнгөөр 17 гүний худгийн усны шаацны савыг сольсон.



"Эрх зүйн хөтөч" хөтөлбөр

АГУУЛГА		№
Тайланг бэлтгэсэн:	Товчилсон үгийн жагсаалт	1
ХөТАГ-ын Нийцлийн аудитын алба	Аудит хийх үндэслэл, зорилт, хамрах хүрээ, арга зүй	2
	Аудитад ашигласан хууль, тогтоомж, шалгуур үзүүлэлт	3
	Үндсэн мэдээлэл	
Тэргүүлэх аудитор О.Ганболд Утас: 99382500		
Аудитын менежер Ж.Отгончимэг Утас: 99382811	<b>Бүлэг 1. Холбогдох хууль журамд нийцүүлэн ОНХС-ийн орлогын эх үүсвэрийг төлөвлөж, бүрдүүлсэн байна.</b>	5
	1.1. Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2.2 заалтыг үндэслэн ОНХС-ийн хөрөнгийг хуваарилсан байна.	
Ахлах аудитор Л.Энх-Амгалан Утас: 96383478	1.2. ОНХС-ийн хөрөнгийн зохих хувийг өмнөх оны өр барагдуулахад болон дамжин хэрэгжсэн ТАХ-г санхүүжүүлэхэд зарцуулсан байна.	6
	1.3. ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд болон дотоод аудитын алба ОНХС-ийн хэрэгжилтийн явцад хяналт тавиагүй байна.	7
	1.4. ОНХС-ийн зорилт үр дүнг нэмэгдүүлэхэд өөрчлөх шаардлагатай эрх зүйн асуудал өмнөх онд гүйцэтгэсэн нийцлийн аудитаар өгсөн саналаас өөр асуудал үгүй байна.	8
2018 оны 10 сар  Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70384043, 70384044 дугаарын утсаар харилцана уу.	<b>Бүлэг 2. Сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих чиг үүрэг бүхий зөвлөл хяналтыг хэрэгжүүлээгүй байна.</b>	9
	2.1 Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн бүрдүүлэлт 62.1 %-тай байна.	
	2.2 Сангийн хөрөнгийн үр дүн хангалтгүй, ажлын байр бодитой нэмэгдсэн эсэхийг баталгаажуулаагүй байна.	10
	2.3 Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, ашиглалт, эргэн төлөлт, тайлагналтад иргэдээр хяналт тавиулаагүй байна.	
	2.4 Шилэн дансанд сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн үр дүнд бий болсон ажлын байрны талаарх мэдээллийг төсөл хэрэгжүүлэгч бүрээр тодорхой оруулдаг цэстэй болох шаардлагатай байна.	11
ХАЯГ:  Мөрөн сум Аймгийн ЗДТГ-ын “А” корпус 3 давхар  Цахим хаяг: audit.mn	<b>Бүлэг 3. Өмнөх аудитын төлбөрийн актыг хэрэгжүүлээгүй байна.</b>	12
	3.1 Өмнөх оны аудитаар өгөгдсөн албан шаардлагын хэрэгжилт 70 хувийн гүйцэтгэлтэй байна.	
	3.2 Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд хийсэн аудитын зөвлөмжийн биелэлт хангалтгүй байна.	13
		14
		15
	4. ДҮГНЭЛТ	
	5. ЗӨВЛӨМЖ	25

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

Товчилсон үг	Тайлбар
УИХ	Улсын их хурал
ЗГ	Засгийн газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
НАГ	Нийцлийн аудитын газар
НА	Нийцлийн аудит
ХөТАГ	Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
ТБОНӨХБАУХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
АОНХС	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжүүлэх сан
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ХБХ	Хөгжлийн бодлогын хэлтэс
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ХХААГ	Хүнс, Хөдөө аж ахуйн газар
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ХА	Харьцуулалтын арга
АТЕЗ	Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ЭМТ	Эрүүл мэндийн төв

## Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

### Аудит хийх үндэслэл

Аудитыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2017 оны “Аудитын сэдэв батлах тухай” 06 дугаар тогтоол, Ерөнхий Аудиторын 2018 оны А/125 дугаар тушаал, ҮАГ-ын 2018 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.

### Аудитын зорилт

Орон нутгийн хөгжлийн сангийн болон Сум хөгжүүлэх сангийн 2017 оны орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, хэрэгжилтийн байдал хууль тогтоомжид нийцсэн эсэх, үр дүнтэй хэрэгжсэн эсэхэд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Уг зорилтын хүрээнд дараах чиглэлээр аудитыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт болон түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй зохион байгуулсан эсэх;
- Сум хөгжүүлэх сангийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт болон түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан эсэх;
- Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэх

### Аудитын хамарсан хүрээ

Аудитыг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 2017 оны орлого бүрдүүлэлт, төсөв төлөвлөгөө, хуваарилалт болон хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга, хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагнал, мөн Сум хөгжүүлэх сангийн 2017 оны орлого бүрдүүлэлт, хуваарилалт, зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлт, түүнд хийсэн хяналт, тайлагнал, холбогдох бусад баримтад тулгуурлан гүйцэтгэв.

Аудитад аймгийн ОНХС болон 13 сумын ОНХС, Сум хөгжүүлэх сан, аймаг, сумдын ИТХ, ЗДТГ, АЗДТГ-ын СТСХ, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэлтэс, Санхүүгийн хяналт, аудитын алба, багийн засаг дарга, Иргэдийн нийтийн хурлыг хамруулав.

### Аудитын арга зүй

Аудитыг АДБОУС 100-400, 4200 дугаар стандартууд, Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журмыг баримтлан шалгагдагч байгууллагаас авсан мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгаж холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, иргэдээс санал асуулга авах, дүн шинжилгээ хийх, анхан шатны баримт, ажлын төлөвлөгөө, тайлантай тулган баталгаажуулах арга зүйг ашиглан аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулан холбогдох албан тушаалтанд хүргүүлж байна.

### Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, эрхийн актуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- ТБОНӨХБАҮХАТ хууль
- Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоол
- Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоол
- Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “ Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”

- Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”
- Сангийн сайдын 2016 оны 17 дугаар тушаалаар батлагдсан “Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн орлогоос орон нутгийн хөгжлийн санд олгох шилжүүлэг тооцох аргачлал”
- Бусад холбогдох хууль, тогтоомж, журам

## **БҮЛЭГ- 1. Холбогдох хууль, журамд нийцүүлэн ОНХС-ийн орлогын эх үүсвэрийг төлөвлөж, бүрдүүлсэн байна.**

### **Үндсэн мэдээлэл**

Монгол Улсын Төсвийн тухай хуульд “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан гэж орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгохоор дахин хуваарилалт хийх хөрөнгийг хэлнэ” гэж заасан байна.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2015 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар 2016 оны төсвийн жилээс эхлэн аймгийн ОНХС-д ОНХНС-аас олгох шилжүүлгээс гадна Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.6<sup>1</sup>, 60.2.7<sup>2</sup>-д заасан шилжүүлгийг улсын төсвөөс олгохоор хуульчилжээ.

ОНХНС болон улсын төсвөөс аймаг, нийслэлийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг тооцохдоо Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”, Сангийн сайдын 2016 оны 17 дугаар тушаалаар батлагдсан “Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн орлогоос орон нутгийн хөгжлийн санд олгох шилжүүлэг тооцох аргачлал”-ыг тус тус мөрдөж байна.

Аймгийн ИТХ-ын 2017 оны 5 дугаар сарын 10-ны 01 дүгээр тогтоолоор аймгийн 2017 оны төсөвт тодотгол хийж, ОНХС-ийн эх үүсвэрт 2,389.2 сая төгрөг баталсан байна.

Хөвсгөл аймгийн ОНХС-д ОНХНС болон улсын төсвөөс 2017 онд 1,986.5 сая төгрөг, “Тогтвортой амжиргаа-3” төслөөс урамшуулал 199.9 сая төгрөг нийт 2,186.4 сая төгрөгийн орлогын эх үүсвэр төвлөрүүлж, хуваарилсан байна. Үүнээс урсгал зардалд 1,150.6 сая төгрөгийг буюу “Хөвсгөл-ус суваг” ХХК-д усны алдагдлын татаас 278.8 сая, Хог хаягдал, устгал, гэрэлтүүлгийн зардалд 344.7 сая, мал эмнэлэг үйлчилгээний зардалд 527.1 сая төгрөг тус тус хуваарилсан байна.

Хөвсгөл аймгийн ИТХ-ын 5 дугаар сарын 10-ны 01 дүгээр тогтоолоор хийсэн төсвийн тодотголоор ОНХС-ийн эх үүсвэрийг дансны үлдэгдлээс 247.5 сая төгрөгөөр, өмнөх оны давсан орлогоос 457.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн нийт эх үүсвэрийг **2,891.2** сая төгрөгөөр баталсан байна.

### **1.1 Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2.2 заалтыг үндэслэн ОНХС-ийн хөрөнгийг хуваарилсан байна.**

#### **1.1.1 ОНХС-ийн эх үүсвэрийг төсвийн төсөл боловсруулах журамд заасан нэр төрлөөр тооцож төлөвлөсөн байна.**

Сангийн яам ОНХНС-аас Хөвсгөл аймагт олгох орлогын шилжүүлгийн төлөвлөлтийг Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 59.2, 59.3 дахь заалтад нийцүүлэн хүн амын тоо, газар нутгийн алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээг харгалзан, усны алдагдал, хог хаягдал, устгал, гэрэлтүүлгийн зардал, мал эмнэлэг үйлчилгээний зардалд тус тус

<sup>1</sup> ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогоос улсын чанартай томоохон төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэгч хуулийн этгээдийн төлсөн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогыг хассан зөрүүний 30 хувь; /Энэ заалтад 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулж “30 хувь” гэснийг “10 хувь” гэж өөрчилсөн, 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар “ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогоос” гэснийг өмнө “Ашигт малтмалын тухай хуулийн 47<sup>3</sup> дугаар зүйлд зааснаас бусад” гэж нэмэлт оруулсан

<sup>2</sup> ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын 50 хувь.

хуваарилан, ЗГ-ын 2012 оны 30 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “ОНХНС болон ОНХС-аас олгох шилжүүлэг тооцох аргачлал”-ын дагуу тооцоолсон байна. Хөвсгөл аймагт ОНХНС-аас 835.9 сая төгрөг, урсгал зардалд 1,150.6 сая төгрөг, “Тогтвортой амьжиргаа-3” төслөөс урамшуулалд 199.9 сая төгрөгөөр төлөвлөж, санхүүжүүлсэн байна.

### 1.1.2 ОНХНС-аас олгох шилжүүлэг, орон нутгийн орлого, давсан орлого, дансны үлдэгдлээс тус тус ОНХС-ийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.

Сумын ИТХ-ын тогтоолуудаар ОНХС-ийн эх үүсвэрт орон нутгийн орлогоос 581.6 сая төгрөг хуваарилан нийт эх үүсвэрийг **3,472.8** сая төгрөг болгосон байна. **Үүнд:**

#### Хүснэгт №1. ОНХС-ийн 2017 оны эх үүсвэр, төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Эх үүсвэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/Сая төгрөг/ Эзлэх хувь
1	ОНХНС-аас олгох орлогын шилжүүлэг	835.9	835.9	24%
2	“Тогтвортой амьжиргаа-3” төслөөс олгох урамшуулал	199.9	199.9	5.7%
3	Улсын төсвөөс урсгал зардалд	1,150.6	1,150.6	33.1%
4	Давсан орлогоос	779.2	779.2	22.4%
5	Дансны үлдэгдлээс	338.8	338.8	9.7%
6	ОНО-ыг нэмэгдүүлэх замаар бий болох эх үүсвэр	168.4	168.4	5.1%
<b>Нийт дүн</b>		<b>3,472.8</b>	<b>3,472.8</b>	<b>100%</b>

**Хүснэгтээс харахад:** ОНХС-ийн нийт эх үүсвэрийн 62.8%-ийг ОНХНС-ийн орлогын шилжүүлэг, “Тогтвортой амьжиргаа-3” төслийн урамшуулал, урсгал зардлын санхүүжилт, 37.2 %-ийг орон нутгийн орлого, дансны үлдэгдэл, давсан орлогоос тус тус бүрдүүлсэн байна.

Хөвсгөл аймаг Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Тогтвортой амьжиргаа-3” төслийн хүрээнд олгосон урамшууллаас бусад дотоод гадаадын хандив, тусламжийн эх үүсвэрийг төлөвлөөгүй байна.

### 1.1.3 ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг Төсвийн тухай хуулийн дагуу хуваарилсан байна.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас Хөвсгөл аймгийн ОНХС-д 2017 онд нийт 2,186.4 сая төгрөгийн шилжүүлгийн орлогыг хуваарилахдаа Монгол Улсын 2017 оны Төсвийн тухай хуулийг дагалдаж гарсан, хууль тогтоомжийн өөрчлөлтүүдийг харгалзан тооцож, хуваарилсан байна.

ОНХС-ийн төсвөөс сумын ОНХС-д нийт төсвийн 30 хувийг буюу 935.1 сая төгрөгийг хуваарилсан нь Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2.2 заалттай нийцэж байна.

2017 онд төлөвлөсөн хэмжээнд ОНХНС-аас 2,186.4 сая төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн орлого, дансны үлдэгдлээс 1,286.3 сая төгрөгийг нэмж аймаг, сумдад ОНХС-ын эх үүсвэрийг дараах байдлаар хуваарилсан байна.

#### Хүснэгт №2 ОНХС-ийн эх үүсвэрийн хуваарь

/Сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	ОНХНС	Үндсэн тэнцлийн ашгийн суурь зарлагатай тэнцэх хэсгийг хассан дүн	Орон нутгийн орлогыг нэмэгдүүлэх замаар бий болгох эх үүсвэр	Дотоод гадаадын хандив тусламж болон бусад	Нийт эх үүсвэр
Аймаг	247.6	1,051.4	457.3			1,756.3
Сумд	91.2	935.1	321.9	168.4	199.9	1,716.5
<b>Нийт</b>	<b>338.8</b>	<b>1,986.5</b>	<b>779.2</b>	<b>168.4</b>	<b>199.9</b>	<b>3,472.8</b>

Хөвсгөл аймгийн ИТХ-ын хуралдааны 2016 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 03 дугаар тогтоолоор ОНХНС-аас олгох орлогын шилжүүлгийг 2,189.3 сая төгрөгөөр баталсан нь СЯ-аас баталсан 2,186.4 сая төгрөгөөс 2.9 сая төгрөгөөр зөрүүтэй байсныг 2017 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор баталсан Төсөвт хийсэн тодотголоор зөрүүг арилгасан байна. Энэ нь “Тогтвортой амьжиргаа-3” төслөөс олгох урамшуулалд 199.9 сая төгрөгийг олгох болсонтой холбогдуулан УИХ-аас улсын төсөвт хийсэн тодотголоор ОНХНС-аас олгох орлогын шилжүүлгийг 202.8 сая төгрөгөөр бууруулж баталсантай холбоотой байна.

ОНХНС-аас болон ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийг хуваарийн дагуу бүрэн санхүүжүүлсэн нь төлөвлөсөн ТАХ-г хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

## 1.2 ОНХС-ийн хөрөнгийн зохих хувийг өмнөх оны өр барагдуулахад болон дамжин хэрэгжсэн ТАХ-г санхүүжүүлэхэд зарцуулсан байна.

### 1.2.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө урьдчилсан саналын жагсаалтыг боловсруулж хэлэлцүүлсэн байна.

Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 6.3<sup>3</sup> хэсэгт заасныг удирдлага болгон Хөвсгөл аймгийн 2017 оны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний урьдчилсан жагсаалт гаргаж сумдаас санал авах арга хэмжээг зохион байгуулж, эрэмбэлсэн байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр нийт 23 ТАХ-г хэрэгжүүлэх урьдчилсан жагсаалтыг гаргаж иргэдээс санал авсан ба хэлэлцүүлэгт 28,117 иргэн оролцсон байна. Иргэдийн саналыг тоолж эрэмбэлэн аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулсан байна.

Аймаг, сумын Засаг дарга тухайн шатны жилийн төсвийн төсөл боловсруулахдаа иргэдээс санал авах, эрэмбэлэх үйл ажиллагааг шат шатанд зохион байгуулсан нь Сангийн сайдын 2014 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 12.1.1<sup>4</sup> дэх заалттай нийцэж байна.

ОНХНС-аас олгох шилжүүлгийг аймгийн ОНХС-д батлагдсан хуваарийн дагуу олгосон нь ОНХС-ийн эх үүсвэрийг бүрэн ашиглах, төлөвлөсөн төсөл, арга хэмжээг тухайн онд хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлсэн байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн арга хэмжээг ангилбал дараах байдалтай байна.

График 1: ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ



Графикаас харахад: Барилга байгууламж 27 %, Их засвар 23 %, Төсөл арга хэмжээ бусад 26%, Тоног төхөөрөмж 16 %, Хөтөлбөрт 8% тус тус зарцуулсан байна.

<sup>3</sup> ...сум дүүргийн иргэдийн саналыг авсан аймаг, нийслэлийн чиг үүрэгт хамаарах саналын жагсаалтыг мөн оруулна.

<sup>4</sup> Аймгийн Засаг дарга тухайн шатны ОНХС-ийн хөрөнгөөр тухайн жилд хэрэгжүүлэх хрөнгөө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний төлөвлөгөөний урьдчилсан жагсаалтыг боловсруулж, жил бүрийн 3 дугаар улиралд багтаан иргэд, олон нийтийн саналыг авна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн үйл ажиллагаанд иргэдийн саналаар эрэмбэлэгдээгүй, худалдан авах ажиллагаатай холбоотой, зориулалт бус зүйлд зарцуулсан, ажлын даалгаврыг өөрчилсөн зэрэг зөрчил илэрлээ. Үүнд:

- Төсвийн төсөл боловсруулахдаа иргэдийн саналаар эрэмбэлэгдээгүй нийт **333.4** сая төгрөгийн дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөгөөнд тусгасан нь Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан зааврын 4.4 (... сум дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх урсгал болон хөрөнгийн зардалд зарцуулахгүй байх) заалтыг зөрчсөн байна.

**Тухайлбал:**

- Цагаан-Үүр сум Эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж авахад 3.0 сая төгрөг, ЗДТГ-ын тоног төхөөрөмж авахад 5.4 сая тус тус баталсан.
- Эрх зүйн хөтөч, 100 хүүхдийн цэцэрлэгийн барилга шинээр барих /Мөрөн/ арга хэмжээнд нийт 325.0 сая төгрөгийг баталсан.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр иргэдээс ирүүлсэн саналыг эрэмбэлж үнэлэхдээ зөрүүтэй нэгтгэсэн байна. Иргэдийн саналаар эрэмбэлэгдсэн ТАХ-ний саналын нэгтгэсэн дүнг Шинэ-Идэр, Цэцэрлэг, Жаргалант сумдаас ирүүлсэн саналын дүнтэй тулган баталгаажуулахад дараах байдалтай байна.

**Хүснэгт № 3**

Иргэдээс гаргасан саналын тоо, эрэмбэ

Эрэмбийн дугаар	Хэрэгжүүлэх ТАХ нэр	Шинэ-Идэр сум		Цэцэрлэг сум		Жаргалант сум	
		Нэгтгэсэн дүнгээр	аудитаар	Нэгтгэсэн дүнгээр	аудитаар	Нэгтгэсэн дүнгээр	аудитаар
		1	Хог хаягдлыг ариутгах автоклав, дагалдах тоног төхөөрөмж авах	98	231	78	176
2	Төв гудамж захын хорооллуудын гэрэлтүүлэг/Мөрөн/	93	312	55	238	57	32
3	Боловсролын чиглэлээр хэрэгжүүлэх ТАХ	108	161	71	101	71	21
4	ЭМ-ийн чиглэлээр хэрэгжүүлэх ТАХ	99	134	76	160	69	26
5	Аялал жуулчлалын чиглэлээр хэрэгжүүлэх ТАХ	87	55	67	164	51	6

**Хүснэгтээс харахад:** Иргэдийн гаргасан санал болон эрэмбэлсэн дүнгээс зөрүүтэй байгаагаас харахад /ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр ирүүлсэн иргэдийн саналыг зөв тооцоогүй байна.

Аймгийн болон сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөж хэрэгжүүлсэн нийт **200** төсөл арга хэмжээнээс дараах ТАХ-үүд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 46 дугаар тогтоолоор баталсан “Хөвсгөл аймгийн 2017-2020 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”, орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдаагүй, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 4.1<sup>5</sup> дэх заалттай нийцэхгүй байна. **Тухайлбал:**

- “Эрүүл Мөрөн” дэд хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлсэн “Хүүхдийн авьяас чадварыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, Хөдөлгөөн эрүүл мэнд” аяны санхүүжилтийн 9.9 сая төгрөгөөс 60 хувьд буюу 6.0 сая төгрөгөөр “Анарпринт” ХХК-иас бичиг хэрэгсэлтэй холбоотой материалыг худалдаж авсан, 3.9 сая төгрөгийг шагнал урамшуулалд зарцуулсан байна.
- “Эрх зүйн хөтөч” хөтөлбөрөөр хэрэгжүүлсэн “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд зориулан малчдын бүлэг хоршоо байгуулахад гарах зардал, “Архигүй-Амгалан амьдрал” арга хэмжээний зардал, “Иргэний эрх зүйн боловсрол эзэмшүүлэх”-д нийт 5.9 сая төгрөг зарцуулсан.
- Галт сум зураг төсвийн зардлыг санхүүжүүлэхээр төлөвлөсөн 25.0 сая төгрөг.

<sup>5</sup> ОНХС-аар хэрэгжүүлэх хөрөнгө оруулал, хөтөлбөр, төсөл арга хэмжээ нь .... тухай орон нутгийн дунд хугацааны хөгжлийн бодлог, төлөвлөлттэй уялдсан байна.



• Сангийн сайдын 2014 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 12.4<sup>6</sup> хэсэг дэх заалт, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 7.4.7 хэсэг<sup>7</sup> дэх заалтыг тус тус зөрчиж ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-ний нэгдсэн жагсаалтад төсөл арга хэмжээний нэр, байршил, саналын тоо, зураг, төсөв нь батлагдаагүй хөрөнгийг хэрэгжүүлэхээр нийт **9.0 сая** төгрөгийн төсөв баталсан байна. **Тухайлбал:**

- Алаг-Эрдэнэ сум халуун усны газрын урсгал засварын 3.1 сая төгрөгийн ажлын зураг, төсөв бэлэн болоогүй байхад төсөв баталсан.
- Чандмань-Өндөр сум гудамжны гэрэлтүүлгийн 3.0 сая төгрөгийн ажлын зураг, ажлын даалгаваргүй, зөвлөх үйлчилгээнд 2.9 сая төгрөгийг баталсан нь ямар эх үүсвэрээр хийгдэх ажилд хөрөнгө баталж байгаа талаар сумын ИТХ-аар хэлэлцээгүй байна.
- Мөрөн сумын 2 болон 3 дугаар багуудын гудамжны гэрэлтүүлгийн ажлын зураг төсөв боловсруулах ажлыг “Электрон сеть” ХХК гүйцэтгэж 2017 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүлээлгэн өгөхөөр гэрээнд тусгасан боловч, 2017 оны 12 дугаар сарын 20-ний өдөр аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүлээлгэн өгсөн нь гэрээний үүргээ хангаагүй байна.

### 1.2.2 ОНХС-ийн хөрөнгийг зориулалтын бус зүйлд зарцуулсан байна.

Аймгийн болон сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-ний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагаатай холбоотой **77.7** сая төгрөгийн дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Аймгийн Засаг даргын 2017 оны 5 дугаар сарын 15-ны А/280 дугаар захирамжаар байгуулсан Үнэлгээний хороо Алаг-Эрдэнэ сумын нутаг дэвсгэрт хэрэгжих “50\*100\* цогцолбор”-ын 600.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын зураг, төсөл гараагүй байхад тендерийн баримт бичгийг баталсан.
- Мөрөн сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих 8 хогийн сав, гоёлын модны үр нийлүүлэх тендер шалгаруулалтыг ХА-аар зохион байгуулсан боловч урилга хүргүүлээгүй “Хөвсгөл Есөн эрдэнэ” ХХК-тай шууд гэрээ байгуулсан нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.2<sup>8</sup> заалтыг зөрчсөн байна. Тендерийн баримт бичиг, ажлын даалгаварт 8 хогийн сав хүлээн авахаар заасан боловч шаардагдах төмөр, цоож, будаг зэрэг материалыг ХТҮТ орлогод авч гүйцэтгэсэн нь тендерийн баримт бичиг, ажлын даалгаврыг хангаагүй байна.
- ОНХСийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн дараах ТАХ-ний ажлын даалгаврыг өөрчилж санхүүжилтийг олгосон, бөгөөд үр дүнг үнэлээгүй байна. **Үүнд:**
  - Жаргалант сумын хогийн цэгийн байгууламжийн 50.1 сая төгрөгийн ажлыг зохиогчийн зөвшөөрөлгүйгээр “Ажлын техникийн тодорхойлолт”-ыг тендерийн баримт бичгийг өөрчилж, сумын Засаг дарга “Хөвсгөл АЗЗА” ХХК-тай № ХӨ-2017/03-1/А гэрээ байгуулан, гүйцэтгүүлсэн байна.
  - Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээнд “Эрүүл иргэн, Эрхэм баялаг” хөтөлбөрөөр эмнэлгийн үзлэг оношилогоонд 100 иргэнийг хамруулах, оношилогооны төлбөрт 15.0 сая төгрөг зарцуулж, хөтөлбөрийн үр дүнг үнэлээгүй байна.

ОНХС-ийн хөрөнгийн **40.8** сая төгрөгийг зориулалт бус зүйлд зарцуулсан байна.

#### Тухайлбал:

- Галт сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн дараах төсөл арга хэмжээ нь чиг үүрэгт нийцэхгүй, зориулалтын бус зүйлд зарцуулсан. **Үүнд:**
  - Уурын зуухны засвар, гадна дулаан цэвэр усны шугамын /концесийн гэрээгээр/ зураг төсвийн үнэ 10.0 сая төгрөг
  - Спорт заалны барилгын /Улсын төсөв/ ажлын зураг-5.0 сая төгрөг

<sup>6</sup> Хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний нэр, байршил, саналын тоо, зарцуулах төсөв

<sup>7</sup> “Зураг төсөв (зөвхөн ОНХС-аас хэрэгжүүлэхээр заасан төсөл арга хэмжээний)”

<sup>8</sup> 33.2.2 “Техникийн болон бусад нөхцөл шаардлагыг хангаж байгаа хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид энэ хуулийн 29.1-д заасны дагуу гэрээ байгуулах эрх олгох”

- Ахмадын өргөөний барилгын/Аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаас/ зураг төсөв-4.0 сая төгрөг байна.
- “Эрх зүйн хөтөч” хөтөлбөрөөр хэрэгжүүлсэн “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд зориулан малчдын бүлэг хоршоо байгуулахад гарах зардал, “Архигүй-Амгалан амьдрал” арга хэмжээний зардал, “Иргэний эрх зүйн боловсрол эзэмшүүлэх”-д нийт 5.9 сая төгрөг зарцуулсан.
- Аймгийн Засаг даргын 2017 оны 06 дугаар сарын 22-ны А/434 дүгээр захирамжаар Мөрөн сумын засаг дарга Ц.Гансүхэд эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн “Эрүүл Мөрөн” дэд хөтөлбөрөөр хэрэгжүүлсэн “Хүүхдийн авьяас чадварыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, Хөдөлгөөн эрүүл мэнд” аяны санхүүжилтийн 60 хувьд буюу 6.1 сая төгрөгөөр “Анарпринт” ХХК-аас бичиг хэрэгсэлтэй холбоотой материалыг худалдаж авсан, шагнал урамшуулалд 3.9 сая төгрөг буюу нийт 9.9 сая төгрөгийн зарцуулсан нь хөтөлбөрийн нийт төсвийн 25 хувийг эзэлж байна. **Үүнд:**

**Хүснэгт № 4 “Эрүүл Мөрөн” дэд хөтөлбөрийн хүрээнд зарцуулсан зардлын жагсаалт /Мянган төгрөгөөр/**

Бичиг хэргийн зардал			
№	Нэр төрөл	Тоо ширхэг	Нийт үнэ
1	Медаль	457	3,199.0
2	Өргөмжлөл	135	675.0
3	Өргөмжлөл/том/	3	6.0
4	Цом	1	42.0
5	Жааз	30	150.0
6	Дурсгалын зүйл	6	300.0
7	Хулдаасан самбар/3*6/	9	1,620.0
<b>Нийт санхүүжилтийн дүн</b>			<b>6,010.4</b>
Шагнал урамшуулал			
<b>Шагнал урамшууллын зардал</b>			<b>3,954.0</b>
<b>Нийт</b>			<b>9,964.0</b>

ОНХС-ийн хөрөнгөөр 2017 онд шинээр хэрэгжүүлсэн 137, өмнөх оноос шилжиж ирсэн 46 нийт 137 төсөл, арга хэмжээнээс 1 ажлыг ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1<sup>9</sup>, 8.1.2<sup>10</sup>, 8.1.3<sup>11</sup> заалтыг үндэслэн нээлттэй, 46 ажлыг харьцуулалтын аргаар, 84 ажлыг шууд гэрээ байгуулах аргаар хэрэгжүүлсэн, дутуу болон хэрэгжүүлээгүй 8 ТАХ байна. Өмнөх оны өр барагдуулах болон дамжин хэрэгжсэн 46 арга хэмжээнд 792.5 сая төгрөг зарцуулсан нь Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 5.11<sup>12</sup> дэх заалттай нийцэж байна.

Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн эрчим хүчний шугам сүлжээ, трансформатороос бусад барилга байгууламж, машин тоног төхөөрөмжийг Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “ОНХС-ийн заавар”-ын 8.6-д заасны дагуу орон нутгийн өмчид бүртгэн ажилласан байна.

Цагаан-Үүр сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн 47.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий агаарын дэд өртөө, эрчим хүчний шугамыг орон нутгийн өмчид бүртгээгүй байна.

<sup>9</sup> Харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар

<sup>10</sup> Шууд худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар

<sup>11</sup> Зөвлөх сонгох бага үний аргыг хэрэглэж болох зөвлөх үйлчилгээний өртгийн дээд хязгаар

<sup>12</sup> ОНХС-ийн хөрөнгийн хэрэгжүүлэхээр тухайн онд төлөвлөж, ажлын гүйцэтгэл баталгаажсан боловч санхүүжилт хийгдээгүй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг дараа жилийн төсөвт тусгаж батлуулна.

Аймгийн ОНХС-ийн 2017 оны санхүүгийн тайланд зардлыг зориулалтаар нь, эдийн засгийн ангиллаар нь хөрөнгийн зардал болон бараа үйлчилгээний бусад зардлаар тус тус тооцож тайлагнасан байна.

**1.3 ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд болон санхүүгийн хяналт, аудитын алба ОНХС-ийн хэрэгжилтийн явцад хяналт тавиагүй байна.**

**1.3.1 ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлтөд хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд хяналт тавиагүй байна.**

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр ТАХ-ний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн үйл ажиллагаанд хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд хяналтыг хэрэгжүүлээгүй, ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд хяналт тавьж ажилласан талаар ажлын тайлан, нотлох баримт үгүй байгаа нь Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 9.1 дэх хэсэгт заасан<sup>13</sup> хяналтууд хэрэгжээгүй зөрчил илэрлээ.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнд ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын хийсэн хяналтын тайлан, үнэлгээг ирүүлэхийг аймгийн ИТХ-ын Ажлын албанд уламжилсан боловч ирүүлсэнгүй.

Өмнөх онд гүйцэтгэсэн “Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалт”-д нийцлийн аудитаар: 2013-2015 онуудын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 1,321.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий төсөл арга хэмжээнүүд иргэдэд үр ашгаа өгч эхлээгүй байгаа хөрөнгийг шийдвэрлэхээр өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс дараах ТАХ-үүд иргэдэд үр ашгаа өгөөгүй байна. **Тухайлбал:**

- Галт сумын халуун усны барилга 49.9 сая төгрөг
- Цагаан-Үүр сум:
  - Багийн иргэний танхим 25.0 сая төгрөг
  - ЭМТ-ийн байрны засвар-10.0 сая төгрөг
  - Гудамжны гэрэлтүүлэг төсөвт өртөг 10.0 сая төгрөг
  - Өөрөө буулгагч автомашин 22.4 сая төгрөг
  - Иргэний танхимын тоног төхөөрөмж 2.8 сая төгрөг
  - Хогийн төвлөрсөн цэг 10.0 сая төгрөг
- Төмөрбулаг сумын халуун усны барилга/ Шатсан/ 20.0 сая төгрөг зэрэг байна.

Эдгээрээс Галт, Төмөрбулаг сумын 69.9 сая төгрөгийн ажил нь өмнөх оны нийцлийн аудитын дүнд орсон болно.

Аудитын зөвлөмж, төлбөрийн актыг хэрэгжүүлээгүй холбогдох албан тушаалтнуудад Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1<sup>14</sup>, 28.2<sup>15</sup> дах заалтуудыг үндэслэн холбогдох албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулах саналыг аймгийн Засаг даргад хүргүүлэхээр шийдвэрлэв.

<sup>13</sup> ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт шалгалтын байгууллагууд тухайн орон нутгийн ИТХ-ын дэргэдэх хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд хяналт тавьж ажиллана.

<sup>14</sup> Төрийн аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, аудит хийлгэхээс зайлсхийсэн, шаардлагатай мэдээлэл, баримт материалыг гаргаж өгөхөөс үндэслэлгүй татгалзсан, аудитад нөлөөлөхийг оролдсон, санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай, сөрөг санал, дүгнэлт авсан, гүйцэтгэлийн болон нийцлийн аудитаар материаллаг шинжтэй зөрчил гаргасан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг төрийн аудитын байгууллагаас эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ.

<sup>15</sup> төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ.

Санхүүгийн хяналт, аудитын албаны хэрэгжүүлсэн аудитаар 2017 оны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа хөрөнгө оруулалт, ТАХ нь Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам” 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын дагуу төлөвлөж, санхүүжүүлсэн гэж дүгнэсэн нь бодит байдалтай нийцэхгүй байна.

### **1.3.2 ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг "Орон нутгийн хөгжлийн сангийн заавар"-ын дагуу хүргүүлээгүй байна.**

Сангийн сайдын 2014 оны 43 тоот тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 10.1<sup>16</sup>, 10.2<sup>17</sup>-т сумын ОНХС-ийн хэрэгжилтийн явцын хагас болон бүтэн жилийн тайланг аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтэст хүргүүлэх, аймгийн Засаг даргын захирамжаар уг тайланд дүн шинжилгээ хийж, ажлын үр дүнг танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийг томилж ажиллуулахаар заасан байтал хэрэгжүүлээгүй байна.

АЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтэс аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд 2017 оны ОНХС-ийн хөрөнгийн хэрэгжилтийн явцыг танилцуулсан байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний үр дүнгийн тайланг Сангийн Яаманд хүргүүлсэн эсэхийг аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн холбогдох мэргэжилтнээс тодруулах, асуулга авахад ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг Сангийн яаманд хүргүүлээгүй гэсэн тайлбар өгсөн болно.

Аймаг, сумдын ОНХС-ийн санхүүжилт, гүйцэтгэсэн төсөл арга хэмжээ, түүний худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийг тухай бүр **shilendans.gov.mn**, **mof.gov.mn** цахим хуудсанд мэдээлсэн боловч аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Чандмань-Өндөр сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн баяр наадмын талбай тохижуулах, Үерийн далан гүүр барих, сумын төвийн гэрэлтүүлгийн худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллийг бүрэн мэдээлээгүй байна.

### **1.4 ОНХС-ийн зорилт үр дүнг нэмэгдүүлэхэд өөрчлөх шаардлагатай эрхзүйн асуудлаар өмнөх онд гүйцэтгэсэн нийцлийн аудитаар өгсөн зөвлөмж хэрэгжээгүй байна.**

“Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ыг Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйл, 60 дугаар зүйлийн 60.11 дэх заалттай нийцүүлэн өөрчлөх шаардлагатай байгаа талаар өмнөх онд гүйцэтгэсэн “Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалт” хийсэн нийцлийн аудитын нэгдсэн тайлангийн дүгнэлтэд үндэслэн Сангийн сайдад зөвлөмж хүргүүлсэн боловч хэрэгжээгүй байна.

### **БҮЛЭГ-2: Сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих чиг үүрэг бүхий зөвлөл хяналтыг хэрэгжүүлээгүй байна.**

#### **Үндсэн мэдээлэл**

2017 оны жилийн эцсийн байдлаар сум хөгжүүлэх сангийн төсвийн эх үүсвэр 2,501.8 сая төгрөг байгаагаас гүйцэтгэлээр 1,033.5 сая төгрөг байна. Сум хөгжүүлэх сангийн төрийн сангийн харилцах данс дахь мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2017 оны эхэнд 585.2 сая төгрөг, эцэст 1,117.1 сая төгрөг байна.

<sup>16</sup> тайланг дараа оны 2 дугаар сарын 1-ний дотор аймаг, нийслэлийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтэст хүргүүлнэ. ОНХС-ийн хэрэгжилтийн үр дүнгийн жилийн эцсийн тайланд дүн шинжилгээ хийж, ажлын үр дүнг танилцуулах үүрэг бүхий ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн даргаар ахлуулсан ажлын хэсгийг Засаг даргын захирамжаар тухай бүр томилж ажиллуулна.

<sup>17</sup> Ажлын хэсэг ОНХС-ийн хэрэгжилтийн байдалд дүгнэлт өгөн, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал зөвлөмжийг сум дүүрэг бүрээр гарган аймаг, нийслэлийн Засаг даргад танилцуулж, шаардлагатай бол тухайн шатны ИТХ-аар жил бүрийн 2 дугаар сарын 25-ний дотор хэлэлцүүлнэ.

Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төслийн үр дүнд шинээр 165 ажлын байр нэмэгдсэн, үүнээс хадгалагдсан ажлын байр 143 байна. АЗДТГ-ын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2017 оны тайлан, статистик мэдээнээс харахад 2017 оны эцэст ажил хайгч 909 иргэн байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 323 иргэнээр буюу 26.2 хувиар буурсан байна.

## **2.1 Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн бүрдүүлэлт 62.1 хувьтай байна.**

### **2.1.1 Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн бүрдүүлэлт хангалтгүй байна.**

Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх орлогыг 2,501.8 сая төгрөгөөр бүрдүүлэхээр төлөвлөсөн ба гүйцэтгэлээр 1,553.0 сая төгрөг буюу 62.1 хувийн гүйцэтгэлтэй байна. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөс төсөл сонгон шалгаруулах замаар зээл олгож, сангийн хөрөнгийг буцаан төлүүлэхээр зээлдэгч нартай гэрээ байгуулан ажилласан байна.

Гэрээнд зээлийн эргэн төлөлтийг график гарган хавсралтаар баталж байгаа боловч зээлийн эргэн төлөлт хугацаандаа хийгдэхгүйгээс сум хөгжүүлэх сангийн хөрөнгө төлөвлөсөн хэмжээнд бүрэн төвлөрөөгүй, гэрээний үүрэг хангагдаагүй байна.

*Галт, Бүрэнтогтох, Рашаант сумд сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, гэрээний үүргийг хангуулан ажиллахад үр дүнтэй ажиллаж 96.0-149.7 сая төгрөгөөр сангийн хөрөнгийг төвлөрүүлсэн байна.*



**Арьс шир боловсруулах төсөл /Цагаан-Уул сум/**

**Оёдол эсгүүр төсөл /Бүрэнтогтох сум/**

### **2.1.2 Зээлийн гэрээний дагуу алдангийг төвлөрүүлээгүй байна.**

Сумын Засаг дарга нар чиг үүргийн дагуу сум хөгжүүлэх сангаас зээл олгох шийдвэр гаргасны дагуу төслийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээдтэй зээлийн болон барьцааны гэрээ байгуулан ажиллаж байна. Гэрээний биелэлтийг хангуулахад хяналт тавьж ажиллаагүй, Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 3.5.5<sup>18</sup> дах заалтыг хэрэгжүүлээгүйгээс зээлийн үндсэн төлбөр, хүү, алданги дансанд бүрэн төвлөрөөгүй байна. Аудитын судалгаагаар: зээлийн хүүгийн орлого төлөвлөгөөгөөр 384.2 сая төгрөг, гүйцэтгэлээр 126.5 сая төгрөг, алданги 4.7 сая төгрөгийг тус тус төвлөрүүлсэн хугацаа хоцорсон зээлийн үлдэгдэл 1,487.7 сая төгрөг байна.

Аудитад хамрагдсан Алаг-Эрдэнэ, Арбулаг, Жаргалант, Түнэл, Цагаан-Үүр, Шинэ-Идэр, Мөрөн, Чандмань-Өндөр сумдын Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт, гэрээний

<sup>18</sup> Зээл, зээлийн хүүгийн орлогыг сангийн дансанд төвлөрүүлэх

үүргийн биелэлт хангалтгүй, зарим иргэд авсан зээлээ **огт төлөөгүй**, зээлийн ихэнх хөрөнгө нь төлөгдөөгүй байна. Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 3.5.5 дахь “Зээл, зээлийн хүүгийн орлогыг сангийн дансанд төвлөрүүлэх” заалтын дагуу сангийн үйл ажиллагааны талаар сумын Засаг дарга нар чиг үүргээ хэрэгжүүлээгүй, хяналтын зөвлөлийн хийсэн шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгаагүй байна.

Сангийн хөрөнгөөс олгосон зээлийг графикаар харуулбал: дараах байдалтай байна.

**График- 2:** Зээлийн судалгаа



Графикаас харахад: Нийт зээлийн 35 орчим хувь буюу 1,487.7 сая төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн, 5 орчим хувь буюу 218.4 сая төгрөгийн зээл зориулалт бус зүйлд зарцуулагдаж төлөгдөх боломжгүй зэргээс чанаргүй зээлд тооцогдсон байна.

## 2.2 Сангийн хөрөнгийн үр дүн хангалтгүй, ажлын байр бодитой нэмэгдсэн эсэхийг баталгаажуулах боломжгүй байна.

### 2.2.1 Төсөл, хөтөлбөрийн зорилтод түвшинг хангаагүй байна.

Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч иргэн, хуулийн этгээд сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн талаарх саналаа төсөл сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлд ирүүлж байна. Сумын засаг даргаар ахлуулсан ажлын хэсэг иргэд, хуулийн этгээдээс ирүүлсэн төслийг тухайн суманд бүртгэлтэй, хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байх, төлбөрийн чадвартай, барьцаа хөрөнгөтэй байх, орон нутагт тулгамдаж байгаа асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн эсэх, ажлын байр нэмэгдүүлэхэд чиглэсэн зэрэг шалгууруудтай нийцэж байгаа эсэхийг хянан, хэлэлцэж шийдвэрлэж байгаа боловч зээлийн эргэн төлөлт хангалтгүйгээс СХС-аас олгох зээл төсвийн зорилтод түвшинг хангаагүй байна.

Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт хангалтгүйгээс зээлийг төлөвлөсөн хэмжээгээр олгохгүй байна. Сангаас олгох зээлийг 2,501.8 сая төгрөгөөр төлөвлөсөн, гүйцэтгэлээр 1,033.5 сая төгрөг болсон байна. /Эх сурвалж: АТЭЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан/

### 2.2.2 Сумын Засаг даргатай байгуулсан зээлийн гэрээний заалтыг иргэд мөрдөхгүй байна.

Журамд заасны дагуу сумын Засаг дарга нар зээлдэгчийн талаар холбогдох баримт бичгүүдийг эх хувиар нь баримтжуулан хадгалж байгаа боловч журмын 4.9<sup>19</sup> хэсэгт заасан төслийн хэрэгжилтийн явц үр дүнгийн талаарх **мэдээллийг баримтжуулаагүй** байна.

Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр төслийг хэрэгжүүлэгч иргэн, хуулийн этгээдтэй зээлийн болон барьцааны гэрээ байгуулж ажиллаж байна. Дамжуулан зээлдүүлсэн зээлээс 2,501.8 сая төгрөгийг төвлөрүүлэхээс 1,553.0 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Аудитаар авсан судалгаагаар хугацаа хоцорсон зээлийн үлдэгдэл оны эхэнд 1,594.1 сая төгрөг байсан бол оны эцэст 1,487.7 сая төгрөг болж буурсан боловч хугацаа хоцорсон зээл, зээлийн хүүгийн орлого нийт зээлийн **34.8** хувийг эзэлж байна.

<sup>19</sup> Сумын засаг дарга энэ журмын 4.9-д зааснаас гадна төслийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаарх бусад мэдээллийг тухай бүр баримтжуулан хадгална.

**Дээрх байдлаас харахад:** Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэхэд анхаарлаа хандуулах шаардлагатай байна.

**Хүснэгт 5:**

2017 оны СХС-аас олгосон зээлийн жагсаалт

№	Аймаг, сумын нэр	2017 оны зээл олголт			Зээлийн үлдэгдэл /2017.12.31-ний байдлаар/	Үүнээс		
		Зээлдэгчийн тоо	Зээлийн хэмжээ	Зээлийн дундаж хүү		Хэвийн	хугацаа хэтрэлтэй	Чанаргүй
1	Алаг-Эрдэнэ	12	52.8	3	294.6	221.2	73.4	
2	Арбулаг	11	45.5	0.63	193.7	120.9	59.2	13.6
3	Баянзүрх	8	67.0	3	187	143.9	28.7	14.3
4	Бүрэнтогтох	12	149.7	0.25	222.5	176.6	35.9	10.0
5	Галт	11	96.0	0.25	275.7	207.8	20.2	47.7
6	Жаргалант				223.1	128.8	82.3	12
7	Их-Уул	18	72.0	0.25	165.7	154.9	10.7	
8	Рашаант	7	100.0	3	192.7	182	10.7	
9	Рэнчинлхүмбэ				144.7	51.4	87	
10	Тариалан	19.0	3.6	3	241.7	187.4	23.9	30.4
11	Тосонцэнгэл				161.4	53.8	104.1	3.5
12	Төмөрбулаг	20	67.0	0.83	166.7	133.5	32.4	0.8
13	Түнэл	7	64.5	3	63.8	48.8		15
14	Улаан-Уул				188.2	90.4	97.8	0
15	Ханх	10	41.3	0.25	33	25.3	7.7	
16	Цагаан-Уул	4	42.0	1.2	209.2	136.1	73.1	
17	Цагаан-Үүр	4	50.0	3	200.4	121.7	78.7	
18	Цэцэрлэг	8	51.0	3.9	190.7	76.1	101.3	
19	Чандмань-Өндөр	7	42.0	1.9	199.7	77.1	73.2	49.4
20	Шинэ-Идэр	4	42.0	2	178	60	58	16.6
22	Эрдэнэбулган	11	44.0	3	135.7	88	42.6	5.1
23	Цагааннуур				155.4	21	134.4	
24	Мөрөн				379	126.6	252.4	0
<b>Нийт</b>		<b>173</b>	<b>958.37</b>	<b>32.46</b>	<b>4236.9</b>	<b>2633.3</b>	<b>1487.7</b>	<b>218.4</b>

Хугацаа хоцорсон 1,487.7 сая төгрөгийн зээлийн 218.4 сая төгрөг нь чанаргүй зээл буюу зориулалтын бус зүйлд зарцуулсан, шүүхээр шийдвэрлэгдэх боломжгүй болоход хүрсэн байна.

**2.2.3 Сум хөгжүүлэх сангийн хөрөнгө зориулалтын дагуу зарцуулагдаагүй, төслийн үр дүнд нэмэгдсэн ажлын байрыг баталгаажуулаагүй байна.**

Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 4 дүгээр зүйлд заасан “Сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төслийн санал, хүлээн авах сонгон шалгаруулах журам”-ын 4.3.6 дах хэсэгт төслийн шалгуурт төсөл нь ажлын байр нэмэгдүүлэхэд чиглэсэн байх гэж заасан.

Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зориулалт ашиглалт, төслийн үр дүнд чиглэсэн хяналт шалгалтын дүнгээс харахад сангийн хөрөнгийн үр дүнд ажлын байр нэмэгдсэн нь тодорхой бус, аудитаар тодорхойлоход хүндрэлтэй нөхцөл байдлын улмаас сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн үр дүнд тодорхой ажлын байр нэмэгдсэн эсэх нь эргэлзээтэй, 2017 оны хувьд шинээр 165 ажлын байр нэмэгдсэн, үүнээс хадгалагдсан ажлын байр 143 гэсэн тоо, мэдээлэл байгаа боловч баталгаажуулаагүй байна.

Шинээр нэмэгдсэн ажлын байр 1783 гэсэн боловч, тодорхой хэсэг хугацаанд хадгалагддаг, байнгын ажлын байр дорвитой нэмэгдээгүй гэж сумдын удирдлагууд, холбогдох мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлага, уулзалтын үр дүнгээс харагдаж байна. Иймд сум хөгжүүлэх сангаас зээл авч байгаа иргэд өмнөх бизнесээ санхүүжүүлэх, мөн түр ажлын байр нэмэгдэх хандлага байна гэж аудитаар дүгнэж байна.

### **2.3 Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, ашиглалт, эргэн төлөлт, тайлагналтад иргэдээр хяналт тавиулаагүй байна.**

#### **2.3.1 СХС-ийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын үр дүнд үндэслэн сумын Засаг дарга нар зохих арга хэмжээг аваагүй байна.**

Сангийн үйл ажиллагаа нийтэд ил тод, нээлттэй байх ба сангийн хөрөнгийн зарцуулалт, ашиглалт, эргэн төлөлт, тайлагналд тухайн сумын иргэд хяналт тавих, шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагаар хяналт шалгалт хийлгэж болох тухай Засгийн газрын 2016 оны 153 дугаар тушаалаар баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 5.1 хэсэг дэх заалтад тодорхойлсон байна.

Аймгийн Засаг даргын 2016 оны 11 дүгээр сарын 04-ний 1/2177 албан тоотоор сумын Засаг дарга нарт сангийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын дүнд зээл барагдуулж ажиллах, хугацаа хэтрэлттэй зээлийн эргэн төлөлтийг барагдуулаагүй нөхцөлд сумын Засаг даргад болон холбогдох бусад албан тушаалтанд хариуцлага тооцож ажиллахыг мэдэгдсэн боловч хугацаандаа зээлээ төлөөгүй иргэдийн асуудлыг шүүхээр шийдвэрлүүлэх арга хэмжээ авч эхэлсэнтэй холбогдуулан хариуцлага тооцож эхлээгүй байна. Аймгийн ХХААГ нь сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийг барагдуулах зорилгоор хугацаа хэтэрсэн өрийг 2017 онд 70%-д хүргэж барагдуулахаар зорилт тавьсан боловч хангагдаагүй байна. Мөн сангийн хөрөнгийн зарцуулалт, ашиглалт, эргэн төлөлт, тайлагналтад иргэдээр хяналт тавиулаагүй байна.

Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн хийсэн шалгалтаар дараах зөрчил илэрсэн байна. **Үүнд:**

СХС-ийн зээлийн ашиглалт, үр дүнгээс ажлын байр нэмэгдсэн эсэхэд дүн шинжилгээ хийгээгүй байна. Чандмань-Өндөр, Бүрэнтогтох сумын ИТХ нь сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны тайланг хэлэлцсэнээс өөр бусад сумын ИТХ сум хөгжүүлэх сангийн тайлан, үр дүнг хэлэлцээгүй байна. Иймд дотоод хяналтыг үр дүнтэй, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн гэж үзэх боломжгүй байна. **Тухайлбал:**

**Шинэ-Идэр сум:** ЗГ-ын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 3.3.2-т зааснаар санхүүгийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт эргэн төлөлтөд хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг сумын ИТХ-ын тэргүүлэгчээр ахлуулах...” гэснийг зөрчиж ИТХ-ын дарга нь тус зөвлөлийн даргаар ажиллаж байна. Сум хөгжүүлэх сангаас зээл авсан иргэдээс зээлээ төлөөгүй байсаар байна.

**Түнэл сум:** Сумын ИТХ-ын 2017 оны 03 дугаар сарын 22-ны 04 дүгээр тогтоолоор Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг шинэчлэн байгуулсан ба тус зөвлөл зээлийн ашиглалт, эргэн төлөлтийн байдалд хяналт хийгээгүй байна.



**Цагаан-Уул сум:** Зээлийн эргэн төлөлтөд тавих хяналт хангалтгүйгээс Сумын ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 01 дугаар тогтоолоор СХС-ийн зээлийн орлогыг 120.0 сая төгрөгөөр орлого бууруулан тодотгол хийсэн байна.

**Алаг-Эрдэнэ сум:** Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хийсэн орон тооны бус зөвлөлийн хяналтаар тухайн төсөл биелэгдэх үндэслэл, эрэлт хэрэгцээ шаардлага байгаа эсэхэд дүгнэлт хийлгүй төсөл сонгон шалгаруулсан нь зээлүүд хугацаа хэтрэх, сум орныхоо хөгжил, засаг даргын мөрийн хөтөлбөр, зээлдэгч нарыг ажлын байр, орлоготой болох тал дээр ямар ч хөшүүрэг болоогүй гэж дүгнэсэн байна. Төсөлд ажлын байр бий болох талаар бичигдсэн боловч тэр нь зөвхөн цаасан дээр үлдсэнээс өөр гүйцэтгэл гараагүй гэсэн байна.

**Цагаан-Үүр сум:** Сум хөгжүүлэх сангийн 2017 оны батлагдсан төсвөөр 139.3 сая төгрөгийн төлөвлөгөөтэй ба гүйцэтгэлээр 44.5 сая төгрөг болж 32,1 хувиар гүйцэтгэл хангагдсан байхад төсвийн гүйцэтгэлтэй холбогдуулан сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл нь зээлийн ашиглалт, эргэн төлөлтийн байдалд хяналт хийгээгүй, ИТХ-д ажлаа тайлагнаагүй байна.

**Галт сум:** Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих ажлын хэсгийн шалгалтад 62 төсөл хамрагдсан ба үүнээс 38 зориулалтын дагуу бүрэн, 27 төсөл зориулалтын дагуу ашиглаагүй, дутуу хэрэгжүүлсэн зөрчил илэрсэн байна.

**Жаргалант сум:** Сум хөгжүүлэх сангаас зээл авсан 2 иргэн авсан зээлээ зориулалтын бус зүйлд зарцуулсан, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, авлагын журналаас зөрүүтэй байна.

### 2.3.2 СХС-ийн хөрөнгийн бүртгэл зөрүүтэй байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагч бүр Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн бүртгэлийг зээлдэгч нэг бүрээр авсан зээлийн зориулалт, хамрагдсан огноо, зээлийн хэмжээ, хүүгийн орлогыг бүртгэж, тайланг жил бүр аудитаар баталгаажуулж байгаа боловч дараах сумдын сум хөгжүүлэх сангийн тайлан бодитой илэрхийлэгдээгүй зөрчил илэрлээ. Үүнд:

- Түнэл сумын Сум хөгжүүлэх сангийн 2017 оны жилийн эцсийн тайлангаар зээлийн үлдэгдэл 127.0 сая төгрөг, хүүгийн үлдэгдэл 5.2 сая төгрөг, алдангийн үлдэгдэл 76.3 сая төгрөг гэж баталгаажуулсан дүнтэй нягтлан бодогчийн тооцоолж гаргасан 277.8 сая төгрөгийн авлагын үлдэгдэлээс **67.1 сая** төгрөгөөр зөрүүтэй байна.
- Арбулаг сумын СХС-ийн зээлийн эргэн төлөлтөд Шүүхээр хураагдсан 12,0 сая төгрөгийн үнэ бүхий зээлийн барьцаа болох хашаа байшинг бүртгэлд тусгаагүй, зээлийн үлдэгдлийг хасаагүй тайлагнасан байна. Сангийн мэдээ мэдээлэл, бүртгэл тайлан зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.

### 2.3.3 Төсөл хөтөлбөрийг зориулалтын дагуу зарцуулаагүй иргэнд хариуцлага тооцоогүй байна.

Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн хугацаа хоцорсон зээлийн үлдэгдэлтэй байгаа, төслийн хөрөнгийг зориулалтын бус зүйлд зарцуулсан иргэдийг шүүхийн байгууллагад шилжүүлж, зээлийг төлүүлэх арга хэмжээ авснаас өөр арга хэмжээ аваагүй, хариуцлага тооцож ажиллаагүй байна. Арбулаг, Алаг-Эрдэнэ, Галт, Шинэ-Идэр, Мөрөн зэрэг сумдын зарим иргэд сангийн хөрөнгийг төлж эхлээгүй, хугацаа хоцорсон байна. **/Хавсралт -1/**

*Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагааг сумын Мал эмнэлэг, үржлийн тасгийн мэргэжилтэнд давхар хариуцуулсан нь сангийн хөрөнгийн ашиглалт, эргэн төлөлтөд тавих хяналт суларсан байна.*

Арбулаг, Алаг-Эрдэнэ, Шинэ-Идэр, Мөрөн сумын Засаг дарга нарт зээлийн хөрөнгийг бүрдүүлэхээр албан шаардлага, Арбулаг сумын сум хөгжүүлэх сан хариуцсан ажилтануудад хариуцлага тооцуулах саналыг сумын Засаг даргад, зээл төлөгдөж эхлээгүй, гэрээний хугацаа дууссан иргэдийн зээлийг төлүүлэх арга хэмжээ аваагүй Засаг дарга нарт

хариуцлага тооцож ажиллах саналыг аймгийн Засаг даргад тус тус хүргүүлэхээр шийдвэрлэв.

## **2.4 Шилэн дансанд сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн үр дүнд бий болсон ажлын байрны талаарх мэдээллийг төсөл хэрэгжүүлэгч бүрээр тодорхой оруулдаг цэстэй болох шаардлагатай байна.**

Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-д өөрчлөлт оруулах санал төрийн байгууллага болон иргэдээс ирээгүй болно. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг буцаан төвлөрүүлээгүй иргэн, эрх бүхий албан тушаалтанд тооцох хариуцлагыг тодорхой болгож, сангийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх хөшүүрэг бий болгох шаардлагатай байна.

### **БҮЛЭГ-3. Өмнөх аудитын төлбөрийн актыг хэрэгжүүлээгүй байна.**

#### **Үндсэн мэдээлэл:**

Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтад хийсэн нийцлийн аудитаар өмнөх онд эрх бүхий албан тушаалтан нарт 34 зөвлөмж, 19.6 сая төгрөгийн 4 төлбөрийн акт, 6 албан шаардлага хүргүүлсэн байна. АТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлж ажиллахаар 2 зөвлөмж өгч ажилласан байна.

#### **3.1. Өмнөх оны аудитаар өгөгдсөн албан шаардлагын хэрэгжилт 70 хувийн гүйцэтгэлтэй байна.**

##### **3.1.1 Аудитын зөвлөмжийн 82.3 хувь орчмыг хэрэгжүүлсэн байна.**

Өмнөх онд гүйцэтгэсэн нийцлийн аудитаар нэр бүхий 5 албан тушаалтанд нийт 28 зөвлөмж өгч ажилласан байна. Аймгийн ИТХ-ын дарга болон Засаг даргад өгсөн 6 зөвлөмжөөс шаардлага хангасан хөтөлбөр, ТАХ-г хэлэлцэн батлах, ОНХС-ийн төлөвлөлт, гүйцэтгэлд хяналт үнэлгээ хийж, нийтэд мэдээлж байх, ОНХС-ийн хөрөнгөөр урсгал болон хөрөнгийн зардалд зарцуулахгүй байх, 2013-2015 оны ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн барилга байгууламжуудыг ашиглалтад оруулж, үр ашгийг иргэдэд хүртээх гэсэн зөвлөмжүүдийн хэрэгжилт **хангалтгүй** байна.

Сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга нарт “Шаардлага хангасан ТАХ-г хэлэлцэн батлах” зэрэг өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүйгээс зөрчил давтагдсаар байна.

##### **3.1.2 Аудитаар өгсөн акт, албан шаардлагын биелэлт 35 хувийн гүйцэтгэлтэй байна.**

ОНХС-ийн зааврын 9.1, 9.4 дэх заалтыг зөрчсөн нийт 6 сумын ИТХ-ын дарга нарт хүргүүлсэн албан шаардлагын биелэлт **70** хувийн гүйцэтгэлтэй, төлбөрийн акт **хэрэгжээгүй** байна.

#### **3.2 Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд хийсэн аудитын зөвлөмжийн биелэлт хангалтгүй байна.**

##### **3.2.1 Аудитаар өгсөн зөвлөмжөөс төсвийн гүйцэтгэлийг хангуулж ажиллахаар өгсөн зөвлөмж хэрэгжээгүй байна.**

АТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан болон сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг үр ашигтай удирдаж, гүйцэтгэлийг хангуулах талаар өгсөн зөвлөмжийн биелэлт 65 %-тай байна.

##### **3.2.2 Акт, албан шаардлага хүргүүлээгүй байна.**

Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд хийсэн аудитаар төлбөрийн акт, албан шаардлага өгөөгүй болно.

**Санал асуулгын талаар:** Нийцлийн аудитаар 9 сумдын нийт 514 иргэнийг хамруулсан санал асуулга явуулсан болно. Санал асуулгын дүн дараах байдалтай байна.

Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа орон нутагт хэрхэн хэрэгждэг, иргэдэд сурталчилдаг эсэх, иргэдэд хүртээмжтэй, үр дүнтэй хэрэгждэг, иргэний оролцоо хэрхэн хангагддаг, эсэхийг дүгнэх зорилгоор авсан санал асуулгын дүнг нэгтгэвэл дараах байдалтай байна. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн талаар:

“Засаг дарга ийнхүү авсан саналыг эрэмбэлж, хамгийн их санал авсан ажлуудыг иргэдэд танилцуулж, нээлттэй хэлэлцүүлэг хийсэн үү” гэсэн асуулгад **Тийм** гэсэн хариултыг асуулгад оролцсон иргэдийн 51.8% нь, “Та орон нутагтаа тус сангийн хөрөнгөөр хийгдэж буй бүтээн байгуулалтын ажлууд бодитой хэрэгжиж байгаа эсэхэд хяналт тавьдаг уу?” гэсэн асуултад **үгүй** гэсэн хариултыг 64.6 % нь өгсөн байна. Санал асуулгын дүнгээс харахад ОНХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний үр дүнг иргэдэд мэдээлж байх, иргэдийн оролцоог хангаж байхыг **иргэд шаардаж** байгаа нь харагдаж байна.

**Сум хөгжүүлэх сангийн талаар:** Сум хөгжүүлэх сангийн талаарх ерөнхий ойлголттой, үйл ажиллагаанд өгөх үнэлгээ **хангалтгүй болон мэдэхгүй** гэсэн хариулт нийт саналын 69.7%-ийг эзэлж байна.

*Нийцлийн аудитаар нийт 1,161.7 сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснээс 408.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 4.0 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 749.3 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв. /Хавсралт 1-д харуулав./*

## ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Холбогдох хууль, журамд нийцүүлэн ОНХС-ийн орлогын эх үүсвэрийг төлөвлөж, бүрдүүлсэн, ОНХС-аас олгох санхүүжилтийг баталсан хуваарийн дагуу бүрэн олгосон нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд үр дүнтэй болсон байна.
2. ОНХС-ийн хөрөнгөөр иргэдийн санал аваагүй, зураг төсөв, ТЭЗҮ хийгдээгүй, мөн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх боломжтой чиг үүргээс бусад төсөл, арга хэмжээг баталж, хэрэгжүүлсэн Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 4.7, 7.4.7 заалтуудыг зөрчсөн байна.
3. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах зарим үнэлгээний хороо, ажлын хэсгүүд холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллаагүй, гүйцэтгэл үр дүнд шинжилгээ хийх ажлын хэсгийг томилон ажиллуулаагүй байна.
4. ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын дагуу шат шатны Засаг дарга нар хүргүүлж, тайлагнаагүй байна.
5. ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлтөд хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд хяналт тавиагүй, аудитын зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.
6. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус хяналтын зөвлөл хяналтыг хэрэгжүүлээгүй, сангийн хөрөнгийн ашиглалт, эргэн төлөлтөд иргэдээр хяналт тавиулаагүй, чанаргүй зээл бий болоход хүргэсэн байна.
7. Зээлийн эргэн төлөлт, ашиглалтыг сумын Мал эмнэлэг, үржлийн тасгийн мэргэжилтэнд давхар хариуцуулсан нь сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт суларч, зөрчил байсаар байна.

## ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурьдсан албан тушаалтанд зөвлөж байна Үүнд:

### **Аймгийн ИТХ-ын дарга Л.Төмөрбаатар:**

1. Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 9.1,9.4 дэх заалтын дагуу ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний төлөвлөлт гүйцэтгэлийн явцад Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагуудаар хяналт тавиулж, үнэлгээ хийлгэн, тайланг сонсож байх.

### **Аймгийн ЗДТГ-ын дарга Х.Ган-Очирт:**

1. Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 9.1,9.4 дэх заалтын дагуу аймаг, сумын ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагатай хамтран ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл арга хэмжээний үр дүнд хяналт тавих.
2. ОНХС-ийн хөрөнгөөр иргэдийн санал аваагүй, зураг төсөв, ТЭЗҮ хийгдээгүй, мөн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх боломжтой чиг үүргээс бусад төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхгүй байх.
3. Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 10.1, 10.2, 10.3-т заасны дагуу ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтэс ОНХС-ийн хэрэгжилтийн тайлан хүлээн авч дүн шинжилгээ хийх, ажлын хэсгийг томилон ажиллуулж, шаардлагатай бол дүнг ИТХ-аар хэлэлцүүлж байх.
4. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хянасан хяналтын хороо, дотоод аудитын хяналтын үр дүнг хэлэлцэж, зөрчил гаргасан этгээдэд хариуцлага тооцож ажиллах.
5. Аймгийн хэмжээнд сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж, гүйцэтгэлийн тайланг хэлэлцэн шийдвэрлэж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлж байх.
6. Хяналт шалгалтын байгууллагуудын өгсөн чиглэл, зөвлөмж, албан шаардлага, төлбөрийн актын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.

### **Сумдын ИТХ-ын дарга нарт:**

1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам батлах тухай Сангийн сайдын 2014 оны 244 дүгээр тушаалыг баримталж ажиллах.
2. Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 9.1,9.4 дэх заалтын дагуу Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагуудаар хяналт тавиулж, үнэлгээ хийлгэн тайланг хэлэлцүүлж байх.

### **Сумдын Засаг дарга нар, ЗДТГ-ын дарга нарт:**

1. Иргэдийн саналаар дэмжигдсэн, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Заавар”-ын 4.7-д заасан шаардлагыг хангасан хөтөлбөр төсөл арга хэмжээг төсвийн төсөлд тусгах.
2. ОНХС-ийн хөрөнгөөр баяр наадам тэмдэглэх, урсгал болон хөрөнгийн зардалд зарцуулахгүй байх.
3. Сүүлийн жилүүдэд ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн барилга байгууламжуудыг ашиглалтад оруулж, үр ашгийг иргэдэд хүртээхэд анхаарч ажиллах.
4. Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгаж, төсвийн гүйцэтгэлийг хангаж, чанаргүй зээлээр бүртгэгдсэн сангийн хөрөнгийг барагдуулахад анхаарч ажиллах.

5. Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд хяналт хийлгэж, дүнг сумын иргэдэд мэдээлж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлж байх.
6. Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 10.1, 10.2, 10.3-т заасны ОНХС-ийн хэрэгжилтийн явц, хагас ба бүтэн жилийн тайланг ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтэс хүргүүлж байх.

#### **Орон нутгийн өмчийн газрын дарга Д.Болд-д**

1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо, ажлын хэсгүүд чиг үүргээ үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэхэд хяналт тавьж ажиллах.
2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг орон нутгийн өмчид бүртгэж, гүйцэтгэл, үр дүнд хяналт тавьж байх.

#### **Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга В.Нэргүй-д**

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнд болон сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд тавих дотоод аудитын хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлж, Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалтын дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийг эрсдлийн удирдлагаар хангаж ажиллах.

**Зөрчлийн жагсаалт**

Хавсралт -1  
/Сая төгрөгөөр/

№	Илэрсэн зөрчлийн Утга	Албан шаардлага			Төлбөрийн акт		Өгсөн зөвлөмж	
		дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
<b>A</b>	<b>ОНХС-ийн талаар:</b>							
1	“Эрүүл Мөрөн” дэд хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлсэн “Хүүхдийн авьяас чадварыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, Хөдөлгөөн эрүүл мэнд” аяны санхүүжилтийн 9.9 сая төгрөгөөс 60 хувьд буюу 6.0 сая төгрөгөөр “Анарпринт” ХХК-аас бичиг хэрэгсэлтэй холбоотой материалыг худалдаж авсан, 3.9 сая төгрөгийг шагнал урамшуулалд зарцуулсан байна.	9.9					1	9.9
2	Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээнд “Эрүүл иргэн, Эрхэм баялаг” хөтөлбөрөөр эмнэлгийн үзлэг оношлогоонд 100 иргэнийг хамруулах, нэг иргэний үзлэг, оношлогооны төлбөрт 150,0 мянган төгрөг буюу 15,0 сая төгрөгөөр гэрээ байгуулсан байна. Мөн тус үзлэг, оношлогоотой холбоотой хүн тээврийн зардалд 3,7 сая төгрөг зарцуулсан байна. Тус хөтөлбөрийн үр дүнг үнэлээгүй.	15.0					1	15.0
3	Төсвийн төсөл боловсруулахдаа иргэдийн саналаар эрэмбэлэгдээгүй арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлсэн. Эрх зүйн хөтөч, 100 хүүхдийн цэцэрлэгийн барилга шинээр барих	325.0					1	325.0
4	“Эрх зүйн хөтөч” хөтөлбөрөөр хэрэгжүүлсэн “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд зориулан малчдын бүлэг хоршоо байгуулахад гарах зардал, “Архигүй-Амгалан амьдрал” арга хэмжээний зардал, “Иргэний эрх зүйн боловсрол эзэмшлүүлэх”-д нийт 5.9 сая төгрөг зарцуулсан.	5.9					1	5.9
5	Цагаан-Үүр сум: Эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж авахад 3.0 сая төгрөг, ЗДТГ-ын тоног төхөөрөмж авахад 5.4 сая тус тус баталсан нь Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 4.4-т тодорхойлсон <sup>20</sup> ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, ТАХ-г төлөвлөхөд баримтлах зарчмыг зөрчсөн байна.	8.4					1	8.4
6	Цагаан-үүр сум: Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс зөрчил хэвээр байна. Үүнд: - Гудамжны гэрэлтүүлэг төсөвт өртөг 10,0 сая төгрөг - Өөрөө буулгагч автомашин 22.4 сая төгрөг - Иргэний танхимын тоног төхөөрөмж 2.8 сая төгрөг - Хогийн төвлөрсөн цэг 10,0 сая төгрөг - Багийн иргэний танхим 25.0 сая төгрөг - ЭМТ-ийн байрны засвар-10.0 сая төгрөг	80.9					1	80.9
8	Алаг-Эрдэнэ сум: Зураг байхгүй, ажлын даалгаваргүй /халуун усны барилга/	3.1					1	3.1
9	Галт сум: ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ нь Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 7.4.7а заалттай нийцэхгүй ТАХ-г хэрэгжүүлэхээр бэлтгэсэн жагсаалтыг сумын ИТХ нь баталж, санхүүжүүлсэн.	25.0	1	21.0	1	4.0		
10	Жаргалант сум: Хогийн цэгийн байгууламжийн ажлын төсөвт өртгийг Монгол Улсын мэргэшсэн төсөвчин хянаж, 50.1 сая төгрөгөөр баталгаажуулсан байна. Тус ажлыг цахим тендер зарлан гүйцэтгэгчээр “Хөвсгөл АЗЗА” шалгарч сумын засаг даргатай № ХӨ-2017/03-1/А гэрээ байгуулан ажилласан байна. Уг гэрээнд “Ажлын техникийн тодорхойлолт” –ыг тендерийн баримт бичгээс өөрчилж, гүйцэтгүүлсэн байна.	50.1					1	50.1

<sup>20</sup> 4.4 (... сум дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх урсгал болон хөрөнгийн зардалд зарцуулахгүй байх)

11	Мөрөн сум: ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих зөрчлийн 5 ширхэг камер, хог ангилан ялгах төвлөрсөн 8 ширхэг хогийн сав нийлүүлэх, гоёлын модны үр нийлүүлэх тендер шалгаруулалтыг хууль, журмын дагуу ХА-аар зохион байгуулаагүй.	12.6					1	12.6
12	Цагаан-Үүр сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн нийт 47.5 сая төгрөгийн төсөв өртөг бүхий цахилгаан, эрчим хүчний шугам, дэд станцыг орон нутгийн өмчид бүртгээгүй байна.	47.5					1	47.5
13	Чандмань-Өндөр сум гудамжны гэрэлтүүлгийн 3.0 сая төгрөгийн ажлын зураг, ажлын даалгаваргүй, зөвлөх үйлчилгээнд 2.9 сая төгрөгийг баталсан нь ямар эх үүсвэрээр хийгдэх ажилд хөрөнгө баталж байгаа талаар сумын ИТХ-аар хэлэлцээгүй байна	5.9					1	5.9
<b>ОНХС дүн</b>		<b>589.3</b>	<b>1</b>	<b>21.0</b>	<b>1</b>	<b>4.0</b>	<b>11</b>	<b>564.3</b>
<b>Сум хөгжүүлэх сангийн талаар:</b>								
13	Мөрөн сум: 2011, 2013 онуудад зээл авсан иргэн Сарангэрэл, Эрдэнэпүрэв, Болдбаатар, Мөнхбаяр, Нямбат, Болормаа, Эрдэнэсайхан, Амартүвшин нарын зээлийн үлдэгдлийн хэмжээ анх авсан зээлийнхээ 70-100 хувьтай тэнцэх буюу 10,0 сая төгрөгөөс дээш үлдэгдэлтэй, буюу нийт 185,0 сая төгрөг байна.	185.0	1	185.0				
14	Цагаан-Үүр сумын СХС-ийн 9 иргэнтэй холбоотой 78,8 сая төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн байна. Нэр бүхий 3 зээлдэгчтэй холбоотой 53.4 сая төгрөгийн зээл нь анх авсан зээлийн 85-100 хувийг төлөөгүй, 2013-2014 онд авсан зээлүүд байна.	53.4					1	53.4
15	Иргэн Наранжаргал, Эрдэнэчулуун, Алтантогос, Батдорж, Энхсайхан, Даваадорж нарын 52,5 сая төгрөгийн зээлийн үлдэгдэл нь 2013 оноос хойш авсан зээл байгаа бөгөөд авсан зээлийн 60-100 хувийг төлөөгүй байна.	52.5					1	52.5
16	Арбулаг сум: СХС-ийн 9 иргэнтэй холбоотой 42.3 сая төгрөгийн хугацаа хоцорсон зээлийн үлдэгдэлтэй байна. Иргэн Бат-Эрдэнэ, Ганбат нарын нийт 17.0 сая төгрөгийн зээл төлөгдөж эхлээгүй, зориулалтын бус зүйлд зарцуулагдсан байхад сангийн хөрөнгийг татан төвлөрүүлэх зэрэг арга хэмжээ аваагүй байна	17.0	1	17.0				
17	Арбулаг сум: Шүүхээр хураагдсан 12,0 сая төгрөгийн үнэ бүхий зээлийн барьцаа болох хашаа байшинг бүртгэлд тусгаагүй,	12.0					1	12.0
18	Түнэл сум: Сум хөгжүүлэх сангийн мэдээлэл тайлангийн дүнгээс 67,1 сая төгрөгөөр зөрүүтэй.	67.1					1	67.1
19	Алаг-Эрдэнэ сумын Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөс 58 иргэдэд олгосон 117,6 сая төгрөгийн зээлийн ашиглалт, зориулалт, үр дүнд хийсэн шалгалтын мөрөөр арга хэмжээ аваагүй байна.	117.6	1	117.6				
20	Шинэ-Идэр сумын Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хийсэн шалгалтын дүнд үндэслэн сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөс 23 иргэдийн 86,000,000/наян зургаан сая/төгрөгийн зээлийн ашиглалт, зориулалт, үр дүнд шалгалт хийгээгүй, авсан зээлээ огт төлж эхлээгүй, арга хэмжээ аваагүй байна.	67.8	1	67.8				
<b>Сум хөгжүүлэх сан дүн</b>		<b>572.4</b>	<b>4</b>	<b>387.4</b>			<b>4</b>	<b>185.0</b>
<b>Нийт дүн</b>		<b>1,161.7</b>	<b>5</b>	<b>408.4</b>	<b>1</b>	<b>4.0</b>	<b>15</b>	<b>749.3</b>



# ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ, САНАЛД ӨГӨХ ТАЙЛБАР

Саналтай холбоотой тайлбар	Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал
Тайлангийн төсөлд өгөх саналгүй.	<div style="display: flex; justify-content: space-around;"> <div style="width: 45%;"> <p style="text-align: center;"><b>ХОВСГОЛ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГ ЧИЙН ХУРДЫН АЖЛЫН АЛБА</b></p> <p style="text-align: center;"><b>ХОВСГОЛ АЙМАГ ДАХЬ ТӨГУЙН АУДИТЫН ГАЗАРТ</b></p> <p>Танай ирүүлсэн "Орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн" нийцлийн аудитын тайлантай танилцла. Орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, гүйцэтгэлд аймгийн ИТХ-ын Хяналтын хороо хяналт тавьж амьшдаг. Хяналтын хөрсөвч 2017 онд хийсэн аймгийн тайланг аудитын явцад хүргүүлээгүй байна. Цаашид аудитын тайлангаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиглана.</p> <p style="text-align: center;">ДАРГА  Ц.ГОМБОР</p> <p style="text-align: center;">Т.А. 05 04.05</p> <p style="text-align: right;">011973106</p> </div> <div style="width: 45%;"> <p style="text-align: center;"><b>ХОВСГОЛ АЙМГИЙН БАСАГ ДАРГЫН ТАНИМЛЫН ГАЗАР</b></p> <p style="text-align: center;"><b>ХОВСГОЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА ТЭГРҮҮЛЭХ АУДИТОР ОЛОНГОЛД ТАНАА</b></p> <p>Орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлд өгөгдсөн зөвлөмжийг ажлаар хэрэгжүүлж болно.</p> <p style="text-align: center;">ДАРГА  Х.ГАН-ОЧИР</p> <p style="text-align: center;">Т.А. 05 04.05</p> <p style="text-align: right;">011973106</p> </div> </div>
Тайлангийн төсөлд өгөх саналгүй.	<div style="display: flex; justify-content: space-around;"> <div style="width: 45%;"> <p style="text-align: center;"><b>ХОВСГОЛ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБА</b></p> <p style="text-align: center;"><b>ХОВСГОЛ АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ</b></p> <p>Сумдын Санхүүгийн албаны дарга нартай хамтран ажиглах гэрээний дагуу тус оянуудад анхын шатанд хяналт хийлгэж, бид даятан хянаж, дотоод хяналтын бэлгэн ажлыг төлөвшүүлэх үндэсн доор Аймгийн Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сангийн гүйцэтгэлд нийцлийн аудит хийх нэгдсэн удирдамжийг аймгийн Засаг даргаар батлуулж хамтарсан хяналтыг хийж, төсвийн өрөнхийлөн захиралчийг эрсдэлийн удирдлагаар ханган ажиглаж байна.</p> <p>Сум орон нутгт дотоод хяналтын үйл ажиллагаа сайжирч байгаа боловч иргэдийн тус оянуудын үйл ажиллагаанд оролцох оролцоо, эзлийн эргэн тусгаланд хяндах хяндлага сул байна. Бид танай нийцлийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиглах болно.</p> <p style="text-align: center;">ДАРГА  В.НЭРҮҮЙ</p> <p style="text-align: center;">Т.А. 05 04.05</p> <p style="text-align: right;">D standart tool A5</p> </div> <div style="width: 45%;"> <p style="text-align: center;"><b>ХОВСГОЛ АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР</b></p> <p style="text-align: center;"><b>АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ</b></p> <p>"Орон нутгийн хөгжүүлэх сан, сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлд өгөгдсөн зөвлөмжийг ажлаар хэрэгжүүлж болно.</p> <p>Үг тайлангийн төсөлд оруулах санал байхгүй байна. Хойшид зөвлөмжийн дагуу ажиг хяналт байгуулан хамтарч ажиглана.</p> <p style="text-align: center;">ДАРГА  Г.БАТТУЛГА</p> <p style="text-align: right;">D standart tool A5</p> </div> </div>

**Тайлбар:** "Орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн" нийцлийн аудитын тайлангийн төсөлд дээрх байгууллагуудаас өөрчлөлт оруулах санал ирүүлээгүй байна.



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОРЫН ТУШААЛ

2019 оны 11 сарын 05 өдөр

Дугаар А/48

Мөнгө сүм

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/125 дугаар тушаал, 2017 оны А/188 дугаар тушаалын тавдугаар хавсралтын 2.4 дэх заалт, 2016 оны А/146 дугаар тушаалаар баталсан "Нийцлийн аудитын түр журам"-ын 9.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу "Орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн"-д хийсэн нийцлийн аудитын тайланг баталсугай.
2. Аудитаар өгсөн акт, албан шаардлагыг хавсралтаар баталгаажуулсугай.
3. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймгийн Засаг дарга, аймгийн Засаг даргын Тамгын газар, Санхүүгийн хяналт, аудитын алба, Орон нутгийн өмчийн газар, сумдын Засаг дарга нар, Хүнс, хөдөө аж ахуйн газарт тус тус хүргүүлсүгэй.
4. Аудитаар өгсөн зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагыг хэрэгжүүлэн ажиллаж үр дүнг 2019 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор багтаан Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга (Л.Төмөрбаатар), аймгийн Засаг дарга (Л.Ганболд), аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Ган-Очир), Орон нутгийн өмчийн газрын дарга (Б.Болд), Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны дарга (В.Нэргүй), сумдын Засаг дарга нарт зөвлөсүгэй.
5. Нийцлийн аудитаар өгсөн албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер (Ж.Отгончимэг), ахлах аудитор (Л.Энх-Амгалан) нарт даалгасугай.


ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ф.ГАНБОЛД

Дата: 2019.11.05

1551148



"Орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн"-д хийсэн нийцлийн аудитаар тогтоосон акт, өгсөн албан шаардлага, хүргүүлсэн хариуцлага тооцох саналын жагсаалт

№	Дугаар	Зөрчлийн товч утга	Мөнгөн дүн /сая.төг/
А Төлбөрийн акт			
1	НАГ-2018/02/- НА-ХөТАГ-01/17	Төсвийг зориулалтын бус зүйлд зарцуулсан	4.0
Б Албан шаардлага			
1	НАГ-2018/02/- НА-ХөТАГ-01/32	Алаг-Эрдэнэ сумын сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөс 58 иргэдэд олгоосон 117,648.500 /Нэг зуун арван долсон сая зургаан зуун дөчин найман мянга таван зуун/ төгрөгийн зээлийн ашиглалт, зориулалт, үр дүнд орон тооны бус хяналтын зөвлөлийн хийсэн шаглалтын мөрөөр арга хэмжээ аваагүй	117.6
2	НАГ-2018/02/- НА-ХөТАГ-01/33	Төсвийг зориулалтын бус зүйлд зарцуулсан	21.0
3	НАГ-2018/02/- НА-ХөТАГ-01/36	Мөрөн сумын нэр иргэд зээл төлж эхлээгүй, гэрээний хугацаа дууссан байхад Засаг дарга нь ямар нэгэн арга хэмжээ аваагүй	185.0
4	НАГ-2018/02/- НА-ХөТАГ-01/34	Шинэ-Идэр сумын нэр бүхий иргэдийн зээл төлөгдөж эхлээгүй, гэрээний хугацаа дууссан байхад арга хэмжээ аваагүй	67.8
5	НАГ-2018/02/- НА-ХөТАГ-05/41	Арбулаг сумын иргэн Д.Бат-Эрдэнэ, А.Ганбат нар 2015-2016 онуудад авсан 17.0 сая төгрөгийн зээлээ гэрээний дагуу төлөөгүй, зориулалтын бус зүйлд зарцуулсан тул санхүүгийн албаны дарга Б.Цэндбаяр, төрийн сангийн мэргэжилтэн Х.Цэрэнванчиг /Хамтран зээлдэгч/, сан хариуцсан нягтлан бодогч Ш.Нарантуяа, жижиг, дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн Д.Амгалан нарт арга хэмжээ авах	17.0
В Арга хэмжээ, сахилгын шийтгэл оногдуулах санал			
6	2018.11.05 04/713	Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх заалтыг үндэслэн Хөвсгөл аймгийн Арбулаг, Түнэл, Шинэ-Идэр, Жаргалант, Цэцэрлэг, Тосонцэнгэл, Цагаан-Үүр, Чандмань-Өндөр, Мөрөн сумын Засаг дарга нарт сахилгын шийтгэл ногдуулах	
Нийт			412.4

\_\_0000\_\_



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

67123 Хөвсгөл аймаг, Мөрөн сум, Үрлэнш бар  
ЗДТГ-ын А хөрөнгө 3 дугаар, Утас/факс: 70-38 07-83  
E-mail: khovsgol@saia.gov.mn  
Website: www.saia.gov.mn

2018.11.15 № 08/118  
Тайлан № \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -г

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА  
Л ГАНБОЛД ТАНАА

**Сахилгын шийтгэл ногдуулах санал  
хүргүүлэх тухай**

Монгол Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2017 оны "Аудитын сэдэв батлах тухай" 08 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/125 дугаар тушаалаар баталсан "Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө"-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд "Орон нутгийн хөгжүүлэх сан, сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн" -д хийсэн нийцлийн аудитгаар дараах зөрчил илэртээ.

Сум хөгжүүлэх сангаас зээл авсан иргэд нь зээлээ гэрээний дагуу төлөөгүй, зориулалтын бус зүйлд зарцуулсан байхад сумдын Засаг дарга нь гэрээний биелэлтийг хангуулаагүй, явц үр дүнд хяналт тавиагүй, ямар ч нэгэн арга хэмжээ аваагүй өдий хүрсэн байна.

Өмнөх аудитын дүн, зөвлөмөлд үндэслэн арга хэмжээ авч ажиллаагүйгээс Цагаан-Үүр сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн төсөл, арга хэмжээнүүд бүрэн хэрэгжээгүй байна.

Иймд холбогдох хуулийн дагуу доорх албан тушаалтнуудад сахилгын шийтгэл ногдуулах саналыг үүгээр хүргүүлж байна. Үүнд:

Арбулаг, Түнэл, Шинэ-Идэр, Жаргалант, Цэцэрлэг, Цагаан-Үүр, Чандмань-Өндөр, Мөрөн сумын Засаг дарга нарт сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2018 оны 12 дугаар сарын 05-ны дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Л. ГАНБОЛД

Ооцолбан бичигтөст-А4

1551323



